

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2 Ордын нөөц	3
1.3 Уурхайн технологийн мэдээлэл	5
1.3 Ил уурхайн олборлолтын технологи	5
1.3.1 Ордын нээлт	5
1.3.2 Уурхайн процесс	6
1.3.3 Ил уурхайн ажиллах горим	7
1.3.4 Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	7
1.3.5 Овоолгын төлөвлөлт	8
1.3.6 Уурхайн тоног төхөөрөмж	8
1.3.7 Өрөмдлөг тэсэлгээний ажил	8
1.4 Дэд бүтэц	9
1.4.1 Уурхайн барилга байгууламж	9
1.4.2 Цахилгаан хангамж	10
1.4.3 Усан хангамж	10
1.5 Эдийн засгийн үзүүлэлт:	13
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2025 ОН/	14
1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
1.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	19
1.3 Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө	19
1.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	19
1.5 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө	20
1.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
1.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
1.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
1.9 Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр	25
1.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
1.11 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	31

Хүснэгтийн жагсаалт

хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилбол	3
хүснэгт 2. Ордын нөөцийн тооцооны хүснэгт	4
хүснэгт 3. Уурхайн бэлтгэл ажил	5
хүснэгт 4. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс	6
хүснэгт 5. Уурхайн ажлын горим	7
хүснэгт 6. Уулын ажлын календарь төлөвлөлт	8
хүснэгт 7. Хуулах хөрсний хэмжээ	8
хүснэгт 8. Овоолгын төлөвлөлт	8
хүснэгт 9. Тэсэлгээтэй болон тэсэлгээгүй хийгдэх уулын ажлын хэмжээ	9
хүснэгт 10. Гүний худгийн солбицол	11
хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	14
хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
хүснэгт 13. Байгалийн бүс бүслүүрийн харгалзан тарих мод, бутыг сонгох	19
хүснэгт 14. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	30
хүснэгт 18. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	31

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Баргилтын төмрийн ордын баруун үргэлжлэлийг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: Гадаадын хөрөнгө оруулалттай “Цахирцагаан гол” ХХК,
Улсын бүртгэлийн дугаар: 9011074096
Регистрийн дугаар: 5068053
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021868

Утас: 7711-4451, 9906-8646
Захирал: Б.Гэрэлт-Од

Төслийн байршил: Хэнтий аймгийн Дархан сумын нутагт Дархан сумаас урагш 20 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, Бор-Өндөр сумаас баруун хойш 14 км зайд байрлана.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилбол

Цэгийн дугаар	Газарзүйн солбицол		UTM-48N	
	Өргөрөг	Уртраг	X	Y
1	46° 20' 01.65"	109° 16' 48.73"	367636.031	5132572.319
2	46° 19' 34.65"	109° 16' 48.73"	367617.929	5131739.016
3	46° 19' 34.65"	109° 18' 31.73"	369820.273	5131691.528
4	46° 19' 12.57"	109° 18' 31.73"	369805.718	5131010.088
5	46° 19' 12.57"	109° 16' 31.73"	367239.643	51311065.421
6	46° 20' 01.65"	109° 16' 31.73"	367272.643	5132580.261

1.2.1. Ордын нөөц

Баргилтын төмрийн ордын баруун үргэлжлэл хүдрийн биетэд хийсэн хайгуулын ажлын үр дүнд тооцсон нөөцийн тооцоогоор уг ордын хэмжээнд бодитой (В) зэргээр, боломжтой (С) зэрэг мөн илрүүлсэн буюу боломжит Р үйлдвэрийн зэргээр нөөц тооцоолов.

Эдгээр хэсэгшлүүдээр бодсон нөөцийн тооцоогоор уг төмрийн хүдрийн ордод бодитой (В) зэргээр 326,825.51 тн хүдрийн, 34.08 %-н төмрийн дундаж агуулгатай 113,523.12 тн төмрийн нөөц, боломжтой (С) зэргээр 230,494.22 тн хүдрийн, 33.57 %-н төмрийн дундаж агуулгатай, 77,376. 91 тн төмрийн нөөц мөн боломжит (Р баялаг) зэргээр 185,909.86 тн хүдрийн 35.16 % - н төмрийн дундаж агуулгатай, 65,374.38 тн төмрийн нөөц тогтоогдсон.


Ордын хэмжээнд бодитой болон боломжтой (В+С) зэргээр нийт нөөц 34.28 %-н төмрийн дундаж агуулгатай 557,319.73 тн хүдрийн нөөц, 190,900.003 тн төмрийн нөөц тооцоолсон. Үүнээс ордын хэмжээнд тооцсон нийт нөөцийн 44%-г бодитой В зэргийн нөөц, 30%-г боломжтой С зэргийн нөөц, боломжит Р илрүүлсэн баялаг 24% - г эзэлж байна.

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилтын төмрийн ордын баруун үргэлжлэлийг ил аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 2.Ордын нөөцийн тооцооны хүснэгт


Блокийн дугаар	Анх батлагдсан геологийн нөөц			
	Хүдрийн эзлэхүүн, мян.м3	Хүдрийн хэмжээ, мян.тн	Fe-ийн дундаж агуулга, %	Металлын нөөц, мян.тн
В-1	48.29	169.96	34.19	58.11
В-2	10.05	35.38	33.94	12.01
В-3	34.51	121.48	35.72	43.39
С-1	22.29	78.46	33.49	26.28
С-2	29.57	104.09	32.52	33.85
С-3	13.62	47.94	35.96	17.24
Нийт В	92.845	326.81	34.73	113.51
Нийт С	65.48	230.49	33.57	77.37
Нийт В+С	158.325	557.30	34.25	190.87

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



Эх сурвалж: Google earth, 2024 он

Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн ерөнхий зураг



1.3. Уурхайн технологийн мэдээлэл

1.3 Ил уурхайн олборлолтын технологи

1.3.1. Ордын нээлт

Зүүн хэсгийн метрийн системийн $X = 368635$, $Y = 5136898.7$ солбицол бүхий цэгээс 10 метрийн өргөнтэй нээгч траншейг нэвтэрч олборлолтын түвшин хүртэл гүнзгийрүүлнэ.

Нөөцийг олборлоход ямар нэг усны нөөцийн түвшинг дайрахгүй тул уул-техникийн нөхцөл харьцангуй хялбар байх бөгөөд хүдрийн биетийн зүүн урд талаас нээж олборлоно. Эхний жилд хөрс хуулалтыг явуулах зориулалтаар 1482 м түвшингээс хөрс хуулалтыг эхлэх нийт 475.15 мян.м³ хөрс хуулна. Иймд үндсэн траншейны ам нь 1482 м түвшингээс эхэлнэ. Үндсэн траншей нь дараах хэмжигдэхүүнүүдтэй байна. Үүнд:

- Өргөн – 10 м
- Гүн – 10 м
- Урт – 109 м
- Орох налуу – 80 промилль
- Эзэлхүүн – 10900 м³
- Траншей нэвтрэх хугацаа – 25 цаг


Бэлтгэл ажлын хүрээнд ил уурхайн хөрс хуулалт, зам талбайг засаж бэлтгэх, техник тоног төхөөрөмжийг байрлуулах, хуваарилах, уурхайн кемпийг байрлуулж, гэрэлтүүлгийг угсарч бэлэн болгох, машин механизмын бэлэн байдлыг хангах зэрэг ажил хийгдэнэ.

Хүснэгт 3. Уурхайн бэлтгэл ажил

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
Шимт хөрс хуулах	м ³	11530
Зам талбай засах	м ³	420
Траншей нэвтрэлт	м ³	10900
Нийт	м ³	22850

1.3.2. Уурхайн процесс

Баруун ордын хүдрийн биетийн геологийн тогтоц нь гадаргууд гаршгүй, эгц босоо уналтай зонхилон баруун урдаас зүүн хойш чигт сунасан биетүүд байгаа. Одоогоор тогтоосон бодитой болон боломжтой зэрэглэлийн нөөцийг нийтэд нь ил уурхайн аргаар олборлоход үүсэх ил уурхайн хөрс хуулалтын хүрээ хязгаарын коэффициент нь харгалзан $1,48 \text{ м}^3/\text{тн}$ байна. Ордыг ил аргаар, автотээвэртэй системээр ашиглах ба уурхайн хөрс хуулалт, болон олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ – ухаж ачих – тээвэрлэх – овоолох гэсэн процессуудаар явуулна.



Хөрс хуулалтын болон хүдэр олборлолтын ажлын доголын өндрийг 5 метр байхаар энэхүү тооцоонд авлаа. Учир нь экскаваторуудын техникийн үзүүлэлтүүдээс хамааруулан тооцоолсон болно. Харин ажлын бус нийлүүлсэн доголын өндрийг 10 м, ажлын бус доголудын хооронд 3.5 метрийн аюулгүйн тавцан буюу берм байхаар тооцоолон ил уурхайнуудыг ТЭЗҮ-д төлөвлөв.

Хүснэгт 4. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт
1	Хүдэр олборлолтын ажлын доголын өндөр	м	5
2	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр: Хатуу чулуулагтай үед	м	5
3	Ажлын бус доголудын нийлүүлсэн өндөр	м	10
4	Ажлын бус доголудын хооронд үлдэх аюулгүйн берм	м	2
5	Хүдэр олборлолтын ажлын доголын налуугийн өнцөг	град	55-65
6	Хөрс хуулалтын ажлын доголын налуугийн өнцөг: • Ажлын • Ерөнхий	град	60-65
7	Экскаваторын орлын өргөн	м	18.4-19
9	Экскаваторын ажлын фронтын урт	м	100-250

Уурхайн автозамыг байгуулахдаа хүдэр олборлолтын ажлын талбайгаас хүдэр хадгалах овоолго хүртэлх, хөрсний чулуулгийг гадаад овоолго хүртэл тээвэрлэх зай нь хамгийн бага байхаар тооцож байгуулсан.

Ордын геологийн тогтоц нь дарагдмал орд тул гадаргууд ойр хэсэгт зузаан хурдас, өгөршсөн материал бүхий харьцангуй зөөлөн материалаар дүүргэгдсэн. Ашиглалтын эхэн үед өрөмдлөг тэсэлгээний ажил шаардлагагүй.

Уурхайн ашиглалт гүнзгийрэх үед ашиглалтын 1 дахь жилээс эхлэн хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийсний дараа экскаватороор хутган автосамосвалд ачиж, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг хүдрийн овоолго хүртэл тээвэрлэн байршуулна.

1.3.3. Ил уурхайн ажиллах горим

Уурхай нь жилийн 6 сарын 15-с 11 дүгээр сар дуустал олборлолт явуулна. Харин улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна.

Хүснэгт 5. Уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Нэгж	Утга
Календарийн хоногийн тоо	хоног	165
Жилд ажиллах хоног	хоног	147
Баяр ёслол, цаг агаарын саатал, сул зогсолт	хоног/жил	5
Урсгал засвар хийх өдрүүд	хоног/жил	13
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

1.3.4. Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Хүчин чадал : Уурхайн жилийн хүчин чадлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн тоног төхөөрөмжийн жилийн нийлбэр бүтээлийг харгалзан тооцоход жилд дунджаар 361-475 мян.м³ хөрс хуулж 267-299 мян.тн хүдэр олборлох боломжтой байна.

Ажиллах горим: Уурхай нь жилийн дөрвөн 6 сарын 15-с 11 дүгээр сарыг дуустал олборлолт явуулна. Харин улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна.

- Жилийн календарийн хоног 165 хоног
- Амралт, баяр ёслолын өдрүүд 5 хоног
- Урсгал засвар хийх өдрүүд 13 хоног
- **Жилд ажиллах хоног - цэвэр 147 хоног**
- Ээлжийн тоо 1 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг

Уулын ажлын календарчилсан төлөвлөлт:

Ил уурхайнууд нь үндсэн олборлолтын хүчин чадалд хүрэх зорилгоор хөрс хуулалт, хүдрийн биетүүдийг нээх, техник, технологиудыг суурилуулах болон бусад бэлтгэл ажлуудыг шийдвэрлэх учир эхний жилүүдэд төслийн хүчин чадлаар бүрэн ажиллаж чадахгүй юм. Иймд нийт эхний жил, сүүлийн жилд бага хүдэр олборлоно гэж үзэн ашиглалтын жилийг хоёр жилээр тогтоон энэхүү ТЭЗҮ-ийн тооцоонд тусгаж байна. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6. Уулын ажлын календарь төлөвлөлт

Ашигла лтын	Хүдэр	Хүдэр	Агуулга	Fe	Хаягдал, 3.2%	Хаягдал Fe	Бохирдо л 4.8%	Хуулах хөрс	Үйлдвэр лэлийн Нөөц	Үйлдвэр лэлийн	Fe
нэгж	м³	тн	%	тн	тн	тн	тн	м³	тн	%	тн
1	80,000	280,000	34,1	95,480	8,960	3,055	13,440	475,145	284,480	32,5	92,425
2	78,320	274,120	34,4	94,298	8,772	3,018	13,158	360,815	278,506	32,8	91,281
Нийт	158,320	554,120	34,2	189,783	17,732	6,073	26,598	835,960	562,986	32,6	183,710

1.3.5. Овоолгын төлөвлөлт

Уурхайн хил хязгаар дотор нийт хөрс 835.96 мян.м³ байгаа бөгөөд хөрсний овоолгод сийрэгжилт тооцсоноор нийт 1,003.52 мян.м³ сийрэгжсэн хөрс байршуулна. Хөрс хуулалтын коэффициент 1.48 м³/тн байна. Сийрэгжилтийн коэффициент 1.2 байна.

Эхний жил 9.6 мян.м³ шимт хөрс хуулна. Хөрсний гадаад овоолго 558.65 мян.м³, шимт хөрсний 11.53 мян.м³ гадаад овоолго үүсгэнэ. Хоёр дахь жил хүдрийн биетийг бүрэн ашиглаж дуусах бөгөөд хөрсний гадаад овоолго 432.98 мян.м³ овоолго үүсгэнэ. Шимт хөрс хуулахгүй.

Хүснэгт 7. Хуулах хөрсний хэмжээ

	Хэмжих нэгж	1-р жил	2-р жил	Нийт
Шимт хөрс	мян.м³	9607	0	9607
Хөрс	мян.м³	465538	360815	826353
Нийт хуулах хөрс	мян.м³	475145	360815	835960

Хүснэгт 8. Овоолгын төлөвлөлт

	Шимт хөрсний овоолго		Хөрсний гадаад овоолго	
	Хэмжээ, мян.м³	Талбай, га	Хэмжээ, мян.м³	Талбай, га
1-р жил	11.53	3.50	558.65	6.11
2-р жил	0	0	432.98	5.03
Нийт	11.53	3.50	991.62	11.14

1.3.6. Уурхайн тоног төхөөрөмж

Өрмийн үндсэн ажлаас гадна өрмийн төхөөрөмжийн ажиллах талбайг засаж тэгшлэх, бэлдэх төхөөрөмж ба туслах тоноглолыг ажилд бэлдэх, өрмийн багаж төхөөрөмж бусад материалаар хангах, өрөмдсөн цооногуудыг эвдрэлтээс хамгаалах, бүртгэл, хэмжилт, төхөөрөмжийн зөөвөр нүүдэл, засвар, зэрэг туслах ажлууд хийгдэнэ. Доголын талбайг өрөмдлөгт бэлдэхдээ талбайд буй саад болох төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах, тэгшлэх, зам засах зэрэг ажлыг голдуу ачигч ашиглан хэрэгжүүлнэ.

1.3.7. Өрөмдлөг тэсэлгээний ажил

Баруун төмрийн хүдрийн ордын уулын ажлыг явуулахад өрөмдлөг тэсэлгээний ажлаар хөрс, хүдрийг сийрэгжүүлэн ухааж ачих ажилд бэлдэх шаардлагатай.

Ордын геологийн тогтоц нь дарагдмал орд тул гадаргууд ойр хэсэгт зузаан хурдас, өгөршсөн материал бүхий харьцангуй зөөлөн материалаар дүүргэгдсэн. Өгөршсөн хэсгийг 5м-ээр тооцож тэсэлгээгүй олборлоно. 5м-ээс доош ил уурхай гүнзгийрэхэд тэсэлгээтэй олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байна.

Хүснэгт 9. Тэсэлгээтэй болон тэсэлгээгүй хийгдэх уулын ажлын хэмжээ

	Хүдэр		Хөрс	
	1-р жил	2-р жил	1-р жил	2-р жил
Тэсэлгээтэй олборлох	284.48	278.5	234.96	360.82
Тэсэлгээгүй олборлох	0	0	240.19	0.00
Нийт	284.48	278.5	475.15	360.82

Баруун ордод ашиглалт явуулах түвшинд ус илрээгүй учраас манай нөхцөлд түгээмэл ашигладаг, харьцангуй хямд төсөр АНФО төрлийн тэсрэх бодисыг тэсэлгээний цооногт ашиглах нь зүйтэй. Сонгосон өрмийн машины үзүүлэлтээс цооногийн диаметр 127 мм байна.

Хөрсний чулуулаг болон хүдэр тус бүрт өөр паспортоор ОТА-г явуулах шаардлагатай.

Өрөмдлөг тэсэлгээний ажлын гол зорилгыг өрөмдлөг тэсэлгээний ажлын нийт зардал болон ачиж тээвэрлэх зардлын, бутлах ажлын нийлбэр зардал бага байх гэж тодорхойлж болно. Өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоог урьдчилан тооцож бодит тэсэлгээний үр дүнгүүдэд шинжилгээ хийж цаашид ОТА-ын параметруудийг нарийвчлан сайжруулах шаардлагатай байдаг. Тэсэлгээний цооног түүний хэмжээс Тэслэх блокт тэсэлгээний цооногийг байрлуулах дизайны үндсэн хэмжээснүүд нь цооногийн диаметр, чулуулгийн бат бэхийн коэффициент, тэсрэх бодисын төрлөөс хамаарах улны бага эсэргүүцлийн шугам, түүнээс хамаарах цооног хоорондын зай, эгнээ хоорондын зай, цооногийн түгжээс, илүү өрөмдлөгийн урт зэрэг болно.

1.4 Дэд бүтэц

1.4.1 Уурхайн барилга байгууламж

Хүний аюул осолгүй, бүтээлтэй ажиллах нөхцөлийг хангах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэл явуулах, машин, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах зориулалттай дараах барилга байгууламжуудыг байгуулах шаардлагатай. Үүнд:

Уурхайн захиргааны барилгууд:

- Уурхайн удирдлагын байр;
- Засвар механикийн цех;
- Эмнэлгийн анхан шатны үйлчилгээний цэг;
- Харуулын байр;
- Шалган нэвтрүүлэх пост;


Уурхайн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, аваар устгах төлөвлөгөө, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааны шуурхай удирдлагыг энэхүү байрнаас зохион байгуулна.

Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа, нийтийн хурал, цуглаан, цаг үеийн шуурхай мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.

1.4.2 Цахилгаан хангамж

Уурхайн шаардлагатай суурилагдсан хүчин чадал 1270.4 кВт, тооцоот хүчин чадал нь 900.1 кВт байгаа тул 440 кВт хүчин чадалтай дизель станц 4 ш, 200 кВт хүчин чадалтай дизель станц 2 ш, сонгосон. Үүнээс тус бүр 1 дизель станцыг нөөцөд ашиглахаар төсөлд тусгалаа.

Цахилгаан хэрэглэгчид



Дизель станц

Уурхайн бүрэн ачаалал болон ажилчдын тосгон, захиргаа, аж ахуйн хэрэгцээ нь нийт бүрэн ачаалал 54.81 кВт учир 80 кВт чадалтай TEKSAN–TJ198DW5C маркийн дизель генератор 1 ширхгийг засварын цех болон ахуйн хэрэглээнд ашиглана.

TEKSAN–TJ198DW5C

Хөдөлгүүр хийц	TEKSAN–TJ198DW5C
Таслуур	3 Pole MCCB
Чадал	158 кВА
Хүчдэл	400 В
Давтамж	50 Гц
Түлшний багтаамж	330 л
Түлш зарцуулалт	
Ачаалал 100%	22 л/ц
Ачаалал 75%	16.5 л/ц
Ачаалал 50%	11.5 л/ц
Жин	1789 кг



1.4.3 Усан хангамж Ордын гидрогеологи

Гидрогеологийн судалгааг ордын гидрогеологийн нөхцөлийн тухай урьдчилсан ерөнхий төсөөлөл авах зорилгоор гүйцэтгэсэн. Баруун төмрийн хүдрийн орд нь 15-30 м харьцангуй өндөртэй жижиг толгод дамнан байрладаг бөгөөд голдуу мезозойн насны магмын чулуулаг болон протерозойн үеийн занар, талст занар, шохойн чулуулаг илэрсэн байна.

Ордын хэмжээнд газрын доорх усны хувьд протерозойн насны талст занар, занарлаг чулуулаг ба шохойлог чулуулаг, гантигаас тогтох ба тэдгээрийн ан цав, тархалт, гипсометрийн түвшигээс хамааран усжилт нь харилцан адилгүй байдаг байна. Нам дор газар гар аргаар малтсан худагт 5-7,5 м орчимд ус илрэх ба гидрокарбонатын, магни-кальцийн найрлагатай, фторын агуулга 2,6-5,4 мг/л байна.

Хайгуулын ажлын явцад нэвтэрсэн уул өрөмдлөгийн ажлын үед 147м хүртэл гүнд ус агуулагч давхарга **илрээгүй** нь ордыг ашиглах үед ямар нэг сөрөг нөлөөгүй болохыг баталж байна.


Ус хангамжийн эх үүсвэр:

Унд ахуйн болон зам талбайн усалгааг гүний худгаас хангана гэж ТЭЗҮ-д тусгасан байна. Төслийн талбайгаас хойш 4 км-т байрлах гүний худгаас усны хэрэгцээг хангана. Гүний худгийн ундарга 1.8 л/сек буюу 155.5 м³/хоног байна.

Хүснэгт 10. Гүний худгийн солбицол

Худаг	Уртраг	Өргөрөг	Усны ундарга
Худаг	109° 17' 06.10"	46° 22' 17.35"	1.8 л/сек

Зураг 3. Гүний худгуудын байршлын зураг



Гүний худаг: Төслийн талбай дээрх гүний худгаас дээж авахад дараах шинж чанартай байна. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна.

Ерөнхий хатуулаг: 4.08 мг-экв/дм³
 pH: 7.39
 ES: 472µS/cm
 TDS: 283ppm
 Исэлдэх чадвар: 2.24 мг/дм³

Ундны ус-худгийн усны ерөнхий хими /2024-09-11/

Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа		
	мг/л	мг/экв	%, мг-экв/л		мг/л	мг/экв	%, мг-экв/л
Cl ⁻	45.4	1.28	22.6	Na ⁺ +K ⁺	36.7	1.59	28.1
SO ₄ ²⁻	32.1	0.67	11.8	Ca ²⁺	64.7	3.23	56.9
NO ₂ ⁻	0.00	0.00	0.00	Mg ²⁺	10.3	0.85	15.0
NO ₃ ⁻	14.0	0.23	4.0	NH ₄ ⁺	0.00	0.00	0.00
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃	213.5	3.50	61.7	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	305.0	5.67	100.0	Дүн	111.7	5.67	100.00

Ус хэрэглээний тооцоо

Уурхайд нийт 33 ажилчид ажиллах ба уурхайн түр хотхонд Нэг ажилчны хоногийн усны хэрэгцээг 20* л гэж үзвэл хоногт 4.95 м³/хон ус, нэг жилд /147 хоног/ 727.65 м³/жил ус хэрэгцээтэй байна.

Унд ахуйн усны тооцоо

Хугацаа	Ажилчдын тоо	1 хүнд ноогдох усны норм хоног/л	Хоногт, м ³ /хоног	Жилд, м ³
1-р жил	33	150	4.95	727.65
2-р жил	33	150	4.95	727.65
Нийт				1,455.3

Зам талбайн усалгааны усны хэрэглээ

Уурхайн зам талбайн нөлөөлөлд өртөх зам талбайд тоосжилт дарах усалгааг салхи шуурга ихтэй 6-10 саруудад буюу 4 сарын хугацаанд нийт 8 удаагийн усалгааг хийнэ.

Тоосжилт дарах усны хэрэглээ

№	Үзүүлэлт	Нэгж	1-р жил	2-р жил	Нийт
1	Нийт услах замын урт	м	3,800	4,100	7,900
2	Замын өргөн	м	4	4	4
3	Нийт замын талбай	м ²	15,200	16,400	31,600
5	Усалгааны норм	л/м ²	2	2	2
6	1 удаагийн усалгааны хэмжээ	м ³ /хон	30.4	32.8	63.2
7	Жилд услах хоног	хоног	8	8	8
8	Жилд хэрэглэх усны хэмжээ	м ³ /жил	243.2	262.4	505.6

Биологийн нөхөн сэргээлт хийх усны хэрэглээ

Ашиглалтын 2 жилийн хугацаанд 20.4 га талбай эвдрэлд өртөнө. Үүнээс 11.93 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийнэ. Биологийн нөхөн сэргээлтийн усалгааг 6 сарын 15-наас 11 сар дуустал буюу нийт 5 сар, 11.93 га талбайг тасралтгүй 7 хоногоор услах буюу өдөрт 2 га талбайгаар усалгааг хийж, жилд 20 удаагийн усалгаа хийнэ. Талбайг хэсэгчлэн 2 га буюу $20,000.0 \text{ м}^2 \times 4 \text{ л/м}^2 = 80 \text{ м}^3/\text{хон} \times 7 \text{ (хэсэгчлэн)} \times 20 \text{ (жилд)} = 11,200 \text{ м}^3/\text{жил}$

Нийт усны хэрэглээ:

Уурхайн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жил		Нийт
			1	2	
1	Ахуйн ус хэрэглээ	м3	727.65	727.65	1455.30
2	Нөхөн сэргээлтийн усалгаа	м3	-	11,200	11,200
3	Тоосжилт дарах усалгаа	м3	243.2	262.4	505.6
Нийт		м3	970.9	12,190.05	13,160.90
Үүнээс: Нэг өдөрт					
1	Ахуйн хэрэглээ	м3/хоног	4.95	4.95	9.9
2	Нөхөн сэргээлтийн усалгаа	м3/хоног	-	80.0	80.0
3	Тоосжилт дарах усалгаа	м3/хоног	30.4	32.8	63.2
Нийт		м3/хоног	35.4	117.8	

Хоногт шаардагдах $117.8 \text{ м}^3/\text{хон}$ усыг $46^\circ 22' 17.35''$, $109^\circ 17' 06.10''$ байршилтай, 1.8 л/сек ($155.52 \text{ м}^3/\text{хон}$)-ийн ундаргатай худгаас хангахаар төлөвлөсөн байна.

Төсөл хэрэгжихэд унд ахуйд $4.95 \text{ м}^3/\text{хон}$, зам талбайн тоос дарахад $32.8 \text{ м}^3/\text{хон}$, биологийн нөхөн сэргээлтийн усалгаанд $80.0 \text{ м}^3/\text{хон}$ ус шаардлагатай ба нийт хоногт $117.8 \text{ м}^3/\text{хон}$ буюу 1.8 л/сек ус ашиглахад хүрэлцээтэй байна.

1.5 Эдийн засгийн үзүүлэлт:

Орд газарт бодогдсон геологийн нөөц болон үйлдвэрлэлийн нөөцөд тулгуурлан жилд 267–298 мян.тн хүдэр олборлох ил уурхай байгуулахад 2 жилийн хугацаанд ашиглаж дуусахаар байна. Уг уурхайг ашиглах 2 жилийн хугацаанд нийт 33 хүний ажлын байр шинээр бий болгон нэг ажилтны сарын дундаж цалин 1,837.1 мян.төг болно.

Улс орон нутгийн төсөвт татвар, төлбөр хэлбэрээр ашиглалтын хугацаанд 4,376.9 сая төгрөг оруулахаар байгаа ба энэ борлуулалтын орлогын 20.3 хувьтай тэнцэнэ.

Төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоогоор төсөл хэрэгжих хугацааны нийт зардал 16.83 тэрбум төгрөг, цэвэр ашиг 4,211 сая төгрөг байна.

Анхны хөрөнгө оруулалтын зардлыг бэлэн мөнгөний эргэлтээрээ 1.05 жилд нөхөн төлнө. Хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийг 10% байхад 3.19 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн норм нь 77.8 %-ийн үзүүлэлттэй байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2025 ОН/

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Жилийн зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	төгрөг	4,350,000
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	төгрөг	-
3	Тэрбум мод тарих төлөвлөгөөний зардал	төгрөг	6,800,000
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	4,546,000

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилтын төмрийн ордын баруун үргэлжлэлийг ил аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг	1,400,000
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	төгрөг	3,250,000
9	Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	төгрөг	-
10	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	төгрөг	2,740,000
11	БОМТ -г орон нутагт тайлагнах	төгрөг	-
Дүн		төгрөг	23,086,000

1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, хэрэгжүүлэх хугацаа болон давтамжийг тусгаж өгөв.

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
1.	Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд	150.0	Тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
2.	Тоосжилт болон бохирдуулагчийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Агаарын тоосжилт үүсгэгч эх үүсвэрүүдийг бүртгэх, мониторинг хийх	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх агаар бохирдуулагчид	200.0	2025 онд	
3.		Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд агаарын тоосжилтын хэмжилтийг шинжлүүлэх /TSP, PM 10, PM 2.5/	-Хөрсний овоолго -Ухаш -Тээврийн зам	ОХШХ-т тусгав.	6, 9-р сард	
4.		Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх /SO ₂ , NO ₂ /	-Хөрсний овоолго -Ухаш -Тээврийн зам		6, 9-р сард	
5.		Гадаад тээврийн хэрэгслийн хурдны хяналтыг мөрдөж ажиллах, GPS суулгах /Дээд хязгаар 50 км/ц/	Уурхайн ашиглалтын талбайд	100.0	2025 онд	
6.		Салхи, шуурга ихтэй үед өрөмдлөг, тэсэлгээ, хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Уурхайн ашиглалтын талбайд	--*--	Үйл ажиллагааны туршид	
7.		Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулах	Гадаад, дотоод тээврийн зам	ҮАЗ-д тусгасан	2025 онд	

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Дүн				450.0		
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
8.	Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил шим алдагдах, бохирдох, эвдрэх, доройтох	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Үйл ажиллагаа эхлэх үед, шинэ газар хөндөх бүрт	ҮАЗ	2025 онд	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
9.		Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх	Уурхай хэмжээнд	1 000.0	Тогтмол	Газрын тухай хуулийн 50.1.1
10.		Хөрс шатах тослох материалаар бохирдохоос сэргийлж ШТС-ын талбайг хатуу хучилттай болгох, аюулгүй ажиллагааг баримтлан ажиллах	ШТС	800.0	2025	MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
11.		Хог хаягдлаар дамжин хөрсний бохирдол үүсгэхгүйн тул хог хаягдлын эцсийн цэгт хүргэх	Ахуйн хог хаягдлын цэг	500.0	2025	MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
12.		Нүхэн жорлонгийн бохирдол хөрс рүү нэвчихээс сэргийлж дотор ханыг бетон болгох	Нүхэн жорлон	500.0	2025	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
13.		Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах, ариутгах зайлуулах	Хогийн цэг	250.0	Тогтмол	
14.		Ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлэх	Уурхайн тосгоны тоосжилтын бууруулж, мод, бут тарих, зүлэгжүүлэх	Барилга байгууламжаас бусад талбай	Нөхөн сэргээлтийн зардалд орсон	
15.						
Дүн				3,050.0		

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
ГАДАРГЫН ДООРХ УС						
16.	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх талаар ажилчдад сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	250.0	2025 онд	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОНБНҮ, Компанийн дотоод журам, Усны менежментийн төлөвлөгөө
17.		Ус ашиглуулах дүгнэлтийг “Усны газар”-аар гаргуулах	Усны хэрэглээгээр	100.0	2025 онд	
18.	Газрын доорх	Гүний худгийн усны түвшинг тогтмол хэмжиж байх	Уурхайн гүний худагт	ОХШХ-д тусгасан	2025 онд	
19.	ус	Гүний усны чанарын үзүүлэлтийг шинжлүүлж, хяналт тавих		ОХШХ-д тусгасан	2025 онд	
Дүн				350.0		
АМЬТНЫ АЙМАГ						
20.	Малын бэлчээрийг доройтуулахаас сэргийлэх	Уурхайн ойр орчимд үржих үлийн цагаан оготны тоо толгойг ихдүүлэхгүйн тулд махчин шувууны үүр талбайн гадна байрлуулах	Төслийн талбайн гадна талд	500.0	2025 онд	
Дүн				500.0		
НИЙТ				4,350.0		

1.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Баргилтын төмрийн ордын баруун үргэлжлэл ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцоолно.

Ашиглалтын үеийн хайгуулын ажлыг ашиглалтын 1 дэх жилээс ашиглалтын тусгай зөвшөөрлийн урд хэсэгт хийх тул хаалтын зардлыг тусгаагүй. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хууль, мөн БОАЖ-ын сайдын баталсан журмуудад зааснаар:

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн зардлын 50%-ийг байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа (бондыг) төрийн сан дахь тусгай дансанд байршуулна.

Төслийн 1 дэх жил болох 2025 онд уул техникийн нөхцлөөр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй тул 2 дох жилээс хийгдэнэ.

1.3 Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт жилд 2000 мод тарихаар сум орон нутагтай зөвшилцсөн.

Хүснэгт 13. Байгалийн бүс бүслүүрийн харгалзан тарих мод, бутыг сонгох

№	Байгалийн бүс бүслүүр		Мод, бут
1	Өндөр уулын бүс		Нарс, шинэс, улиас, улиангар, хус, бургас, монос, чацаргана, нохойн хошуу, шар хуайс, боролзгоно, голт бор
2	Уулын тайгын бүс		
3	Ойт хээрийн бүс		
4	Хээрийн бүс	Нугын хээр	Хайлаас, бургас, монос, чацаргана, нохойн хошуу, шар хуайс, боролзгоно, голт бор
		Хээр	
		Хуурай хээр	
5	Говийн бүс	Цөлжүү хээр	Заг, тоорой, жигд, сухай, гүйлс, хармаг
		Заримдаг цөл	
6	Цөлийн бүс	Хээржүү цөл	
		Жинхэнэ цөл	
		Хэт гандуу цөл	

БОМТ-нд мод тарих, арчлах зардлыг тусгаж өглөө.

2000* 3400 төг (суулгацны үнээр тооцов) * 1жил= 6,800,000 төгрөг

1.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн MV-021868 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

1.5 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

1.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 14. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг,стандарт аргачлал
1	Тарвага нутагшуулахад орон нутагт 10 сая төгрөгийн хандив өгнө.	Орон нутгийн саналын дагуу	-	—	ҮАЗ-д тусгасан	2025 онд	MNS 5914:2015, MNS 4597:2013
2	Ажилчид болон уг төсөлтэй холбоотойгоор төслийн талбайд ирэх хүмүүст хууль бус ан агнуурын тухай сануулга, өгч хууль тогтоомжийг танилцуулан ан агнуур хийлгэхгүй байх арга хэмжээг авах	Орон нутгийн саналын дагуу	-	-	1,546	2025 онд	
3	Шаардлагатай тохиолдолд биотехникийн ажил зохион байгуулах	Орон нутгийн саналын дагуу	-	-	3,0	2025 онд	
Нийт дүн, мян.төг				4,546			

1.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Хээрийн түймэр уурхайн талбай, кемп рүү орж ирэх, уурхайн хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаах дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Дотоод журам	2025 онд он
	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	150.0	Жилд 1 удаа
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр уурхай эхлэх үед
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	250.0	Жил бүр, жилд 1 удаа
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	1 000.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал		1 400.0	

1.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮		Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Энгийн хог хаягдлын ангилан ялгадаг хогийн савыг тавих	Уурхайн хотхон	500.0		Төслийн эхэн үед	
	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	500.0		Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	ШТС, Ажилчдын байр	500.0		Төслийн эхэн үед	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэр, гэрээт компанид нийлүүлэх	Зориулалтын хаягдлын цэгт хадгалагдсан хаягдал дугуй	-	750.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэр, гэрээт компанид нийлүүлэх	Зориулалтын задгай талбайд хаягдал тосыг хадгалах	Хэрэглээний хэмжээгээр			
	Машин механизмд ашигласан аккумуляторыг тусгай агуулахад хадгалж, гэрээт компанид нийлүүлэх	Зориулалтын хаягдлын цэгт хуримтлагдсан аккумуляторыг	-			Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	500.0		Төслийн эхэн үед	
	Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэлттэй болгох	Уурхайн ашиглалтын талбайд	500.0		Төслийн эхэн үед	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	Зориулалтын хог хаягдлын цэг	ҮАЗ		Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Ашигласан тос, маслог хийх зориулалтын сав, цэгтэй байх					

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилтын төмрийн ордын баруун үргэлжлэлийг ил аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	ҮАЗ	Төсөл хэрэгжих хугацаанд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
			3 250 000		

1.9. Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Цахирцагаан гол” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалан төлөвлөгөөтэй нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Цахирцагаан гол” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Цахирцагаан гол” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын тоосны шинжилгээг хийлгэх /Нийт тоосонцор, PM10, PM2.5/	Үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт	Тоосжилт үүсгэх эх үүсвэрүүдэд Уурхайн ухашийн салхины дор 109° 16' 44.365" 46° 19' 56.039"	6, 9-р сард	75 000 төг х 3 үзүүлэлт х 3 цэг х жилд 1 удаа Нийт 675.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
1.2	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх /SO ₂ , NO ₂ CO/	Үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт	Хөрсний овоолгын салхины дор 109° 16' 40.158" 46° 19' 42.217" Зам 109° 16' 44.919" 46° 19' 34.856"			

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
						MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
НИЙТ 675.0						
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний агрохими хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолго 109° 16' 39.417" 46° 19' 54.010"	Жилд 2 удаа /6, 9-р сард/	цэгт х 2 удаа х 25.0 мян.төг х 1 жил НИЙТ 150.0 /Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж -25.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001
2.2	Хөрсний хүнд металлын агууламж	Хөрс хүнд металлаар бохирдох, хөрс рүү нэвчих, гүний усыг бохирдуулах	Зам 109° 16' 33.634" 46° 19' 53.743" Кемп 109° 16' 47.429" 46° 19' 57.808"	Улиралд 1 удаа жилд 2 удаа/ /6, 9-р сард/	цэгт х 1 дээж х жилд 2 удаа х 75.0 х 1 жил Нийт 450.0 /Хүнд металлын шинжилгээ 1 дээж- 75.0 төг/	Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никелийг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
2.3	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Хөрсөөр дамжин гэдэсний халдварт өвчин, нянгийн өвчнөөр өвчлөх	Кемп 109° 16' 47.429" 46° 19' 57.808"	Жилд 1 удаа /9 сард/	Микробиологи 1 цэгт х 1 дээж х жилд 1 удаа х 30.0 х 1 жил Нийт 30.0 /Эрүүл ахуйн шинжилгээ 1 дээж-30.0 төг/	

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
						MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
НИЙТ 630.0						
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний худаг	Өөрсдийн гүний худаг 109° 17' 6.100" 46° 22' 17.350"	6, 9-р сард	Усны шинжилгээ 50.0 х 1 цэг х 2 удаа х 1 жил = 100.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
2.2	Усны чанар Микробиологи	Усны эрүүл ахуйн шинжилгээ		6, 9-р сард	Усны шинжилгээ 30.0 х 1 цэг х 2 удаа х 1 жил = 60.0	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж
2.3	Усны түвшин усны ундарга, нөөц	Гүний худаг		6, 9-р сард	Худгийн түвшин хэмжилт 1 худаг х 2 удаа х 50.0 х 1 жил= 100.0	MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
НИЙТ 260.0						
Ургамлын аймаг						

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилтын төмрийн ордын баруун үргэлжлэлийг ил аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
3.1	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биоамасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамлын судалгаа	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө, шинэ газар хөндөгдөх болгонд,	Шимт хөрсний овоолго 109° 16' 37.797" 46° 19' 53.685" Ногоон байгууламж	Жилд 1 удаа	500.0	Байгаль орчны мэргэжилтэн, ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					2,740.0 мян.төг	

1.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Гэрээний үнийн дүнгээр	2025	Газрын тухай хуулийн 58.5
Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 ¹ болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	2 жил тутамд	Гэрээний үнийн дүнгээр	2025	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах	Уурхай хаагдахаас 3 жилийн өмнө	-	-	БОНБУнэлгээний тухай хуулийн 14.1.3-т зааснаар
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	тохиролцох	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Галын аюулгүй байдлын дүгнэлт авах	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төсөв	Эхний жилд	Онцгой байдлын ерөнхий газар
Тэмээний баярт зориулан орон нутагт дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төсөв	Эхний жилд	Нийгмийн хариуцлагын гэрээ
Б.Яндаагийн нэрэмжит бөхийн барилдаанд орон нутагт дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төсөв	Эхний жилд	Нийгмийн хариуцлагын гэрээ
Нийт, сая.төг	Гэрээний үнийн дүнгээр тооцно.			

1.11 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Цахирцагаан гол” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 18. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах Хамтарч ажиллах	-
БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн БОМТ, тайлан	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-